

БАТЛАВ.

ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН
ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ *Б.НАРАНТУЯА*

**“ЭРҮҮЛ АМЬДРАЛЫН ТӨЛӨӨ-2019” УРЬДЧИЛАН
СЭРГИЙЛЭХ ҮЗЛЭГ, СУРГАЛТЫН УДИРДАМЖ**

ХА0456 9085331

Үндэслэл:

Монгол улсад Эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээг хийлгэх шаардлагатай эрхтэн тогтолцооны эмгэгтэй, түүний төгсгөлийн үе шатанд байгаа элэг нэгт иргэд олон байна.

Хүн ам өсөн нэмэгдэж байгаа болон хүрээлэн буй орчин, амьдралын хэв маяг, хэрэглэж буй хоол хүнс зэрэгтэй уялдаатай амин чухал эрхтнүүд болох бөөр, элэг, зүрх судас, уушиг, нойр булчирхайн хүнд хэлбэрийн эмгэгүүдээс гадна хорт хавдрын эмгэг ихсэж байна. Архи, тамхи, өөх тостой ихтэй хоол унд хэтрүүлэн хэрэглэж хөдөлгөөний хомсдол, таргалалт, чихрийн шижин өвчин улам бүр нэмэгдэж энэ нь цаашлаад эрхтэн тогтолцооны эмгэгийн төгсгөлийн үе шатанд хүргэж эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээ хийлгэх нөхцөлд байдалд оруулж байна. Үүний зэрэгцээ мэдээлэл, харилцаа улам хөгжиж ард иргэд дэлхийн хөгжилтэй орнуудад эдгээр өвчний төгсгөлийн үе шатанд ямар эмчилгээ хийж буй талаар өргөн мэдээлэл авч Эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээг гадаад оронд олноороо очиж хийлгэдэг болоод байгаа билээ. Зөвхөн сүүлийн 3 жилд 350 гаруй хүн эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээ гадаад улсад хийлгэсэн гэсэн мэдээлэл байна. Эмчилгээний зардалд хэр их хэмжээний зардал чирэгдэл гарсан нь тодорхой билээ.

Сүүлийн үед элэгний В болон С вирусийн эсрэг эмчилгээ сайжирч, гемодиализийн төвүүд олширч, диализийн машины тоо өсөн нэмэгдэж, эмчилгээний зардлыг төр дааж буй зэрэг нь ард иргэддээ чиглэсэн төр засгаас авч хэрэгжүүлж буй томоохон ажил хэрэг билээ.

Гэсэн хэдий ч ард иргэд өөрсдийн эрүүл мэндийн төлөө хариуцлага хүлээж, санаа зовинож, өвчин эмгэгээс хэрхэн урьдчилан сэргийлэх, эрүүл зөв зохистой амьдралын хэв маягийг хэвшүүлэх цаашлаад урьдчилан сэргийлэх үзлэгт тогтмол хамрагдаж өвчнөө эрт оношлуулж эмчийн хяналтанд эмчилгээг цаг алдалгүй хийлгэж байх ёстой билээ.

Зорилго:

Эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээнд хүргэж буй өвчин эмгэгээс хэрхэн урьдчилан сэргийлэх талаар ард иргэдийн эрүүл мэнд болон нийгмийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, амьдралын хэв маягийг өөрчлөх, зөв хандлага бий болгох, цогц мэдээлэл өгөх.

Хаана зохион байгуулах: УНТЭ, УГТЭ, Сүхбаатар, Баянзүрх, Сонгинохайран дүүргийн нэгдсэн эмнэлэг, АШУҮИС, Ач анагаах ухааны их сургууль, Глобал дээд сургууль, Этүгэн дээд сургууль

Зохион байгуулах байгууллага: ЭМЯ, Эрүүл Мэндийн Хөгжлийн Төв, УНТЭ, ЭШСМХолбоо

Сургалтад оролцогчид:

Иргэд, оюутан залуучууд, Дүүргийн болон өрхийн эмч мэргэжилтнүүд

Зорилт:

1. Иргэдийг эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээнд хүргэж буй зонхилон тохиолддог өвчин эмгэгүүдийн талаар болон түүнээс хэрхэн урьдчилан сэргийлэх талаар бүрэн хэмжээний мэдлэг, мэдээллээр хангах
2. Иргэдийг эрүүл, зөв зохистой амьдрах хэв маягийг хэвшүүлэх өөрсдийгөө болон гэр бүлээ дээрх өвчнөөс хэрхэн урьдчилан сэргийлэх мэдээллээр хангах

Хэрэгжүүлэх хугацаа:

2019 оны 10 дугаар сарын 01 – 2019 оны 12 дугаар сарын 01-ний өдөр

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

- Ард иргэдэд урьдчилан сэргийлэх үзлэг, эрүүл мэндийн сургалт, зөвлөгөө өгөх зэргээр нийгмийн эрүүл мэнд, эрүүл амьдралын зөв дадал эзэмших, өвчнөөс хэрхэн урьдчилан сэргийлэх талаар мэдлэг мэдээллийг хүргэх

Сургалтын хэлбэр: Сургалтыг танхимын хэлбэрээр явуулна. Багш эрүүл зөв амьдралын тухай лекцийг үзүүлэн таниулах, тараах материал ашиглан явуулна.

Санхүүжилт: 34,400,000₮

Хүлээгдэж буй үр дүн:

1. Төслийн үр дүнд иргэдийг эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээнд хүргэж буй зонхилон тохиолддог өвчин эмгэгүүд, түүнээс хэрхэн урьдчилан сэргийлэх талаар мэдлэг, мэдээллээр хангаж улмаар иргэдийг эрүүл, зөв зохистой амьдрах хэв маягийг хэвшүүлэх, өөрсдийгөө болон гэр бүлээ дээрх өвчнөөс хэрхэн урьдчилан сэргийлэх тухай тодорхой, цэгцтэй мэдээллээр хангагдана. Сургалтад хамрагдсан 1 хүн цааш 4 хүнд мэдээлэл түгээх маягаар нийгмийн эрүүл мэндийн мэдээлэл олон нийтэд хүрнэ.
2. Нийт сургалтад хамрагдсан иргэдийн 30 хувь нь эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээнд хүргэж буй зонхилон тохиолддог өвчин эмгэгүүдээс урьдчилан сэргийлж чадна гэж тооцоход 300 хүн уг өвчнөөс өөрсдийгөө хамгаалснаар эрүүл мэнд, ялангуяа санхүүгийн нөхцөл байдлаа бүрэн хамгаалж чадна.

БАТЛАВ
ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН
ЗАХИРАЛ *Б.Нарантуяа* **Б.НАРАНТУЯА**

Эрүүл амьдралын төлөө-2019 456 9086331

МЯН.ТӨГ

№	Зардлын зүйл	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Зардлын жишиг	Нийт зардал
Урьдчилан сэргийлэх аян өрнүүлэх төслийн ажлын төлөвлөгөө					
Сургалт зохион байгуулах ажлын хүрээнд					
1	Бичиг хэрэг	1 хүн	350	2.000	700.000
2	Бусад зардал/бичгийн цаас, скоч, самбарын үзэг, утасны зардал гэх мэт бусад/				144.280
3	Материал олшруулах	1 нүүр	4000	50	200.000
4	Баннер хэвлүүлэх	м2/ширхэг	17.1м2/3	4.400	225.720
5	Урсдаг зар, мэдээ	1 удаа	75	4.000	300.000
6	Зохион байгуулагчийн ажлын хөлс	хүн/өдөр	4/14	20.000	1120.000
	Туслах ажилтны ажлын хөлс	хүн/өдөр	1/14	15.000	210.000
Сургалтын багшийн ажлын хөлс					
7	Магистр	хүн/өдөр/цаг	3/14/2	10.000	840.000
8	Доктор профессор	хүн/өдөр/цаг	5/14/2	20.000	2800.000
9	Цайны зардал	хүн/өдөр	12/14	5.000	840.000
10	Хоолны зардал	хүн/өдөр	12/14	15.000	2520.000
Нийт					9900.000
Урьдчилан сэргийлэх үзлэг хийх ажлын хүрээнд					
1	Эмчийн үзлэг	хүн	1000	15.000	15000.000
2	Цуллаг эрхтний эхо	хүн	475	20.000	9500.000
Нийт					24500.000
НИЙТ ДҮН					34400.000

БАТЛАВ:

ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН
ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ *Мунуу* Б.НАРАНТУЯА




**“ЭРҮҮЛ АМЬДРАЛЫН ТӨЛӨӨ 2019” СЭДЭВТ
СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР**

УНТЭ-ийн хурлын заал	
Үргэлжлэх хугацаа: 2019.11.02 – 2019.11.24	
8.30-9.00	Бүртгэл
9.00-09.20	“ЭРҮҮЛ АМЬДРАЛЫН ТӨЛӨӨ 2019” сэдэвт сургалтын нээлтийн үйл ажиллагаа ЭМХТ-ийн Эс, эд, эрхтнийг шилжүүлэн суулгах үйл ажиллагааг зохицуулах албаны дарга П.Батчулуун УНТЭ-ийн Ерөнхий захирал Т.Мөнхсайхан ЭШСМХ-ны Ерөнхийлөгч Д.Нямсүрэн
09.20-10.05	Бөөрний эмгэгээс хэрхэн урьдчилан сэргийлэх вэ? /УНТЭ Анагаах ухааны доктор Д.Баян-Өндөр/
10.05.-10.55	Элэгний эмгэгээс хэрхэн урьдчилан сэргийлэх вэ? /Анагаах ухааны доктор П.Батчулуун/
10.55-11.40	Төмөр дутлын цус багадалт /Анагаах ухааны доктор Н.Оюундэлгэр/
11.40-12.25	Артерийн даралт ихсэлт, түүнээс урьдчилан сэргийлэлт /Анагаах ухааны магистр А.Ганцэцэг/
Эдүгээр өдөр	
13.00-13.45	Зүрх судасны эмгэгээс хэрхэн урьдчилан сэргийлэх вэ? /Анагаах ухааны магистр Б.Тайхар/
13.45-14.30	Вируст гепатит түүний хүндрэл, урьдчилан сэргийлэлт /Анагаах ухааны доктор Д.Даваадорж/
Дайны завсарлага	
14.40-15.25	Цусны эмгэгээс хэрхэн урьдчилан сэргийлэх вэ? /Анагаах ухааны магистр Б.Хишигжаргал/
15.25-16.10	Бөөрний үрэвсэлт өвчин, урьдчилан сэргийлэлт /Анагаах ухааны доктор Л.Од-Эрдэнэ/
16.10-17.00	Асуулт хариулт



МОНГОЛ УЛСЫН ГАСГИЙН ГАЗАР
ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ



Улсын Нэгдүгээр
Төв Эмнэлэг



“ЭРҮҮЛ АМЬДРАЛЫН ТӨЛӨӨ - 2019”

/Нийгмийн эрүүл мэндийг дэмжих төсөл/

Улаанбаатар хот

2019 он

ТӨСЛИЙН АГУУЛГА

1. ТАНИЛЦУУЛГА

- 1.1. Төслийн үндэслэл
- 1.2. Төслийн зорилго
- 1.3. Төслийн зорилт
- 1.4. УНТЭ-ийн Эрхтэн шилжүүлэн суулгах төвийн танилцуулга
- 1.5. Эрхтэн Шилжүүлэн Суулгах Монголын Холбооны танилцуулга

2. ХҮН АМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГА:

- 2.1 Бодлогын бичиг баримтад тусгагдсан чиглэлээр
- 2.2 Үйлчлэх хүрээний хүн амын тоо
- 2.3 Ядуу эмзэг бүлгийн хүн амд хүрч үйлчлэх байдал

3. САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН ХҮЧИН ЗҮЙЛ:

- 3.1 Төслийг хэрэгжүүлэх санхүүжилт
- 3.2 Улс, орон нутгийн эрүүл мэндийн талаарх бодлого, стратегид туссан байдал

4. ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНД ОРУУЛАХ ХУВЬ НЭМЭР:

- 4.1 Нийгэм эдийн засгийн ач холбогдол
- 4.2 Хүний нөөцийн мэргэшсэн байдал
- 4.3 Төслийн хүрэх үр дүн

1.1. ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ

Монгол улсад Эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээг хийлгэх шаардлагатай эрхтэн тогтолцооны эмгэгтэй, түүний төгсгөлийн үе шатанд байгаа элэг нэг иргэд олон байна.

Монгол улсад өнөөдрийн байдлаар 24 Гемодиализийн төвийн 160 машинд 690 гаруй хүн 7 хоногт 2-3 удаа гемодиализийн эмчилгээнд орж байгаа нэг удаагийн эмчилгээний зардал нь 130000-180000₮ болдог байна.

Элэгний В вирусийн тархалт нь нийт хүн амын 8 –аас дээш хувийн тархалттай орнуудын тоонд орж байгаа бөгөөд жил бүр 2000- 2200 гаруй хүн элэгний хатуурал болон хавдар шинээр оношлогддог ба тэдгээрийн 80% нь анх оношлогдсон жилдээ нас барж байна. Мөн эдгээр элэгний хорт хавдрын 50-60% нь HBV-ын шалтгаантай байгаа ба В вирусийн шалтгаан элэгний хавдрын тохиолдол нь дэлхийн дунджаас даруй 6 дахин их байгаа юм. Уг эмгэгийн 30 гаруй хувь нь D вирус тэй хавсарсан байна.

Харин HCV нь хүн амын 10-12 хувьд тархсан байна.(The Lancet 2011, Central of Disease Analysis 2013, ЭМХТөв 2014 он)

Түүнчлэн хүн ам өсөн нэмэгдэж байгаа болон хүрээлэн буй орчин, амьдралын хэв маяг, хэрэглэж буй хоол хүнс зэрэгтэй уялдаатай амин чухал эрхтэнүүд болох бөөр, элэг, зүрх судас, уушиг, нойр булчирхайн хүнд хэлбэрийн эмгэгүүдээс гадна хорт хавдрын эмгэг ихсэж байна. Архи, тамхи, өөх тостой ихтэй хоол унд хэтрүүлэн хэрэглэж хөдөлгөөний хомсдол, Үүний зэрэгцээ мэдээлэл, харилцаа улам хөгжиж ард иргэд дэлхийн хөгжилтэй орнуудад эдгээр өвчний төгсгөлийн үе шатанд ямар эмчилгээ хийж буй талаар өргөн мэдээлэл авч Эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээг гадаад оронд олноороо очиж хийлгэдэг болоод байгаа билээ. Зөвхөн сүүлийн 3 жилд 350 гаруй хүн эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээ гадаад улсад хийлгэсэн гэсэн мэдээлэл байна. Эмчилгээний зардалд хэр их хэмжээний зардал чирэгдэл гарсан нь тодорхой билээ

Сүүлийн үед В болон С вирусийн эсрэг эмчилгээ сайжирч, Гемодиализийн төвүүд олширч, диализийн машины тоо өсөн нэмэгдэж, диализийн эмчилгээний зардлыг төр дааж буй зэрэг нь ард иргэддээ чиглэсэн төр засгаас авч хэрэгжүүлж буй томоохон ажил хэрэг билээ.

Гэсэн хэдий ч ард иргэд өөрсдийн эрүүл мэндийн төлөө хариуцлага хүлээж, санаа зовиож, өвчин эмгэгээс хэрхэн урьдчилан сэргийлэх, эрүүл зөв зохистой амьдралын хэв маягийг хэвшүүлэх цаашлаад урьдчилан сэргийлэх үзлэгт тогтмол хамрагдаж өвчнөө эрт оношлуулж эмчийн хяналтанд эмчилгээг цаг алдалгүй хийлгэж байх ёстой билээ.

1.2. ТӨСЛИЙН ЗОРИЛГО

Эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээнд хүргэж буй өвчин эмгэгээс хэрхэн урьдчилан сэргийлэх талаар ард иргэдийн эрүүл мэнд болон нийгмийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, амьдралын хэв маягийг өөрчлөх, зөв хандлага бий болгох, цогц мэдээлэл өгөх.

1.3. ТӨСЛИЙН ЗОРИЛТ

- I. Эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээнд хүргэж буй зонхилон тохиолддог өвчин эмгэгүүдийн талаар болон түүнээс хэрхэн урьдчилан сэргийлэх, илрүүлэх, эмчлэх талаар сургалт, ярилцлага зохион байгуулах.
- II. Эрүүл, зөв зохистой амьдрах хэв маягийг хэвшүүлэх чиглэлээр зөвлөгөө, сургалт хийх
- III. Иргэд, оюутан залуус хамт олныг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж өвчнийг эрт оношлох, эмчилгээ зөвлөгөө өгөх

1. ТАНИЛЦУУЛГА

1.4. УНТЭ-ИЙН ЭРХТЭН ШИЛЖҮҮЛЭН СУУЛГАХ ТӨВИЙН ТАНИЛЦУУЛГА *УНТЭ-ийн Эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээний товч мэдээлэл*

Анхны бөөр шилжүүлэн суулгах мэс заслыг Улсын Клиникийн Төв Эмнэлэгт 1996 онд хийсэн бөгөөд өнөөдрийг хүртэл Монгол улсад Эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээний үйл ажиллагаа Улсын Нэгдүгээр Төв Эмнэлэг /УНТЭ/ дээр төвлөрөн хийгдэж хөгжиж дэвжиж байна.

УНТЭ-ийн бөөр шилжүүлэн суулгах баг /цаашид БШС/: 2006 онд байгуулагдсан. Энэ хугацаанд БНСУ-ын КОЙКА олон улсын байгууллагын дэмжлэгтэйгээр 250000\$-ын үнэ бүхий эд нийцлийн болон дархлаа дарангуйлах эмийн тун үздэг лабораторийн тоног төхөөрөмж нийлүүлэгдсэн. 2006 оноос өнөөдрийг хүртэл бөөр шилжүүлэн суулгах баг нь МУ-ын 177 иргэнд амьд донороос бөөр шилжүүлэн суулгасан ба тэдгээрээс 16 хүнд цогцосноос буюу кадавр донороос бөөр шилжүүлэн суулгах мэс заслын эмчилгээг амжилттай хийгээд байна. Энэ хугацаанд Засгийн Газар болон төсвөөс БШС мэс заслыг дэмжиж ямар нэг санхүүжилт хийгдээгүй байна.

2006 оноос хойш одоог хүртэл нэг хагалгааны зардлыг 12 сая төгрөгөөр тооцож, үүний 8 сая төгрөгийг ЭМ-ийн сайдын багцнаас гаргаж, үлдсэн 4 сая төгрөгийг эмчлүүлэгч өөрөө гаргадаг байна. Гэвч одоогийн нөхцөлд донор болон реципиентийн мэс заслын эмчилгээ, түүний дараахь 28 хоногийн эмчилгээ нь нийтдээ 32 сая төгрөг шаардагдаж байна гэж тооцоолсон. Одоо УНТЭ-т 170 гаруй хүн 7 хоногт 2-3 удаа гемодиализын эмчилгээнд орж байна. Гемодиализын нэг удаагийн эмчилгээний өртөг нь 120-140\$ байдаг.

УНТЭ-ийн Элэг шилжүүлэн суулгах баг 2007 онд байгуулагдсан. Одоогоор баг нь нийт 30 гаруй гишүүнтэй ба гишүүд АНУ, БНСУ, Австри, Герман, Финлянд улсад урт богино хугацаагаар элэг шилжүүлэн суулгах мэс заслын арга техникт суралцсан. Элэг шилжүүлэн суулгах эмчилгээний төслийн хүрээнд 2011 онд ЗГ-аас 600 сая төгрөг, 2012 онд 1.2 тэрбум төгрөгийн санхүүжилт хийгдэж, элэг шилжүүлэн суулгах эмчилгээнд шаардлагатай тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл авсан.

МУ-ын элэг шилжүүлэн суулгах үндэсний баг /цаашид ЭШСБ/ нь 2011 оны 9 дүгээр сард анх удаа амьд донороос элэг шилжүүлэн суулгах мэс заслыг

БНСУ-ын АСАН төвийн элэг шилжүүлэн суулгах багийн хамт олонтой хамтарч амжилттай хийж гүйцэтгэсэн. Одоогоор нийт 69 эмчлүүлэгчдэд амьд донороос, 2 эмчлүүлэгчид тархины үхэлтэй донороос элэг шилжүүлэн суулгах эмчилгээг амжилттай хийж гүйцэтгээд байна. 2014 оны 1 сард анх удаа хүүхдэд элэг шилжүүлэн суулгах мэс заслыг амжилттай хийсэн. Эдгээрээс амьд донороос элэг шилжүүлэн суулгах 11 мэс заслын эмчилгээг МУ-ын Элэг шилжүүлэн суулгах үндэсний баг бие даан амжилттай хийж гүйцэтгэсэн. 2012 он хүртэл гадаад орнуудад (БНСУ, БНХАУ, Сингапур, Япон, Энэтхэг) элэг шилжүүлэн суулгах мэс заслын эмчилгээ хийлгэсэн 20 гаруй хүн байсан бол сүүлийн 3 жилд гадаад оронд 300 орчим хүн элэг шилжүүлэн суулгах мэс засал хийлгэсэн байна. Гадаад орнуудад элэг шилжүүлэн суулгах мэс заслыг 50-250 мянган долларт хийдэг нь зөвхөн мэс заслын зардал юм. Элэг шилжүүлэн суулгах багийн тооцоогоор уг мэс заслын эмчилгээний зардал нь 85-100 сая төгрөгт болж байна.

УНТЭ-ийн Ясны чөмөг, үүдэл эс шилжүүлэн суулгах баг 2010 онд байгуулагдсан. Ясны чөмөг шилжүүлэн суулгах төслийн хүрээнд 2010 онд ЗГ-ын төсвөөс 300 сая төгрөгөөр шаардлагатай лабораторийн тоног төхөөрөмж хангагдаж эхэлсэн. 2012 онд энэ төслийг дэмжиж ЗГ нэмэлт 2.6 тэрбум төгрөг санхүүжилтээр өгч, Класс 100 фильтр бүхий ариун иж бүрэн тоноглогдсон хэсгийг дэлхийн стандартын дагуу барьж байгуулсан. Ясны чөмөг, үүдэл эс шилжүүлэн суулгахад шаардлагатай лабораторийн тоног төхөөрөмжөөр тоноглогдсоны үр дүнд 2014 оны 2 дугаар сард анхны ясны чөмөг шилжүүлэн суулгах эмчилгээг хийсэн ба одоо 14 хүнд уг эмчилгээг амжилттай хийж гүйцэтгээд байна.

Цусны хавдар болон хавдар төст эмгэгийн улмаас ясны чөмөг үүдэл эс шилжүүлэн суулгах эмчилгээ хийлгэхээр жилд дунджаар 4-5 хүн гадаад орныг зорьж байна. Эмчилгээний зардал нь ойролцоогоор 200-230 сая төгрөг болдог. Уг төрлийн өвчнээр Монгол улсад жилд 50 орчим том хүн, хүүхдэд оношлогддог байна.

УНТЭ дээр ЭШСТөв 2012 онд байгуулагдсан бөгөөд төвийг 2016 оны 1-р улиралд УНТЭ-ийн өргөтгөлийн байрны 2 давхарт 3 боксын өрөөтэй, 2 том өрөөтэй, нийт 8 ортой, 8 оронд хяналтын монитор, ханын хүчилтөрөгч, вакуум соруулга, бусад цахилгаан хэрэгслээр иж бүрэн тоноглогдсон шинэ

байранд нүүлгэн шилжүүлж 04 дүгээр сарын 20-нд нээлтийн үйл ажиллагааг хийсэн. Уг төв ЭШС эмчилгээнд орох шаардлагатай эмчлүүлэгч нарыг болон тэдгээрийн доноруудыг бүртгэж, хяналтандаа авч зохих эмчилгээ, үйлчилгээ, шинжилгээнүүдийг бүрдүүлж, бэлтгэлийг хангадаг. ЭШС эмчилгээнд орж эмчлүүлэгч нарын мэс заслын болон мэс заслын дараахь эрчимт эмчилгээнд шаардлагатай бүх эм тариа, ороох боох материал, цус, цусан бүтээгдэхүүн, зэргийн захиалга хангалтыг бүрдүүлдэг. Үүний зэрэгцээгээр ЭШС эмчилгээтэй холбоотой бүх эрх зүйн актуудыг бэлтгэн эмчлүүлэгч болон ар гэрийнхэнд нэг бүрчлэн танилцуулж гэрээ байгуулан баталгаажуулах зэрэг олон талт ажлыг хийдэг. ЭШС мэс заслын дараах хамгийн нарийн түвэгтэй, мэдлэг, дадлага туршлага, тэсвэр тэвчээр шаардсан эрчимт эмчилгээний хүнд хүчир ажлыг ЭШСТөвийн эмч, сувилагч, үйлчлэгч нар бөөр болон элэг шилжүүлэн суулгах багийн гишүүдийн хамт хийж гүйцэтгэдэг. Мөн амбулаторын хэсэгт 2015 оноос кабинетаар эрхтэн шилжүүлэн суулгасаны дараах урт хугацааны хяналтын үйл ажиллагааг тогтмолжуулан ажиллуулж гадаад болон Монгол улсад бөөр шилжүүлэн суулгасан 240, элэг 210, зүрх шилжүүлэн суулгасан 1 хүнийг хянаж дархлаа дарангуйлах эмийг хяналтын дор сар бүр олгож байна.

Тус төв нь Эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээг өргөжүүлэх, эрх зүйн орчныг цогц болгох, донорын асуудлыг шийдвэрлэх зорилгоор дараах ажлуудыг зохион байгууллаа. Үүнд:

1. 2016 оны 12 дугаар сарын 05-ны өдөр Эрхтэн шилжүүлэн суулгах үндэсний багийн элэг шилжүүлэн суулгах багийн гишүүд Засгийн газрын ордонд Улсын Их хурлын нэр бүхий гишүүдтэй "Донорын тухай хууль"-д нэмэлт өөрчлөлт оруулан эрх зүйн орчныг сайжруулахад анхаарч өгөх талаар уулзалт хийсэн. Тус хуулийн төслийг 2016 оны 12 дугаар 15-ны өдрийн ЭМЯ-ны удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн дэмжүүлсэн.
2. ЭШСТ-ийн гишүүд нь "Эрхтэн шилжүүлэн суулгалтыг зохицуулах зөвлөл" байгуулах төслийг боловсруулан ЭМЯ-ны 2016 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэгдсэн. Мөн донорын тухай хуулийн төслийн шинэчилсэн найруулгад эрх зүйн талаас тусгаж өгсөн.

3. Эрүүл мэндийн сайдын 2016 оны А/147 тоот “Ажлын хэсгийн бүрэлдэхүүн шинэчлэн батлах тухай” тушаалаар ЭМЯ, УНТЭ, АШУУИС, Эмгэг судлалын үндэсний төв, ЦССҮТ, ГССҮТ, Донорын холбоо, Диализаар эмчлүүлэгчдийн Чандмань Холбоо зэрэг төрийн болон төрийн бус байгууллагуудын эмч, эмнэлгийн мэргэжилтэн, иргэдийг оролцуулсан 23 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байгуулагдан “Донорын тухай хууль”-д нэмэлт өөрчлөлт оруулан, донорын тухай хуулийн үзэл баримтлал, хуулийн төсөл боловсруулах ажлыг зохион байгуулж хуулийн үзэл баримтлалыг боловсруулан ЗГ-ын 2016.11.02-ны хуралдаанаар хэлэлцүүлэн дэмжүүлж УИХ-д өргөн барьж НББСШУ-ны байнгын хороо, УИХ-ын нэгдсэн чуулганаар тус тус хэлэлцэгдээд батлагдсан.
4. 2019 оны 01 дүгээр сарын сарын 19-ний өдөр Донорын тухай хууль шинэчлэгдэн батлагдсан. Уг хуульд заасны дагуу 03 дугаар сарын 01-ний өдөр Эрүүл мэндийн хөгжлийн төвийн бүтэц зохион байгуулалтад нэмэлт өөрчлөлт хийн Эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах үйл ажиллагааг зохицуулах алба 6 орон тоотойгоор байгуулагдаж ажиллаж байна.
5. Эрхтэн шилжүүлэн суулгах төв нь тархины үхэлтэй донороос эрхтэн шилжүүлэн суулгах төслийг элэг, бөөр, зүрх, нойр булчирхай, нүдний эвэрлэг шилжүүлэн суулгах чиглэлээр боловсруулан батлуулахаар ЭМЯ-нд хүргүүлсэн. Тархины үхэлтэй донороос зүрх, нойр булчирхай, нүдний эвэрлэг шилжүүлэн суулгах багууд шинээр томилогдон удирдамж боловсруулан бэлтгэл ажил хийж сургалтын төлөвлөгөө гарган ажиллаж байна.
6. УНТЭ-ийн ЭШСТ-өөс III шатлалын донор эмнэлгүүд болох УГТЭ, ГССҮТ-тэй донорын чиглэлээр хамтран ажиллах гэрээг 2016 оны I-р улиралд байгуулж байсан. ЭМХТ-ийн ЭЭЭШСҮАЗА нь 2019 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр гурвалсан гэрээг УНТЭ, ХСҮТ, УГТЭ, ГССҮТ-тэй 3 жилийн хугацаатай байгуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.
7. Элэг, бөөр шилжүүлэн суулгах эмчилгээ хийлгэсэн эмчлүүлэгчдийг хяналтанд авч, тархины үхэлтэй донороос элэг, бөөр шилжүүлэн суулгахаар хүлээгдэж эмчлүүлэгч нарыг Хүлээх жагсаалтад бүртгэн тэдгээрийн мэдээллийг цусны бүлэг бүрээр нь бүртгэн, нэгдсэн бүртгэл мэдээллийн сан бий болгоод байна.

1.5. ЭРХТЭН ШИЛЖҮҮЛЭН СУУЛГАХ МОНГОЛЫН ХОЛБООНЫ ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

Эрхтэн шилжүүлэн суулгах Монголын холбоо /цаашид ЭШСМХ/ нь 2015 оны 04 дүгээр сарын 14-ны өдөр Улаанбаатар хотод УНТЭ-ийн байранд анхны хурлаа хийж байгуулагдсан. ЭШС суулгах энэхүү хүнд, хэцүү нөр их ажилд хамрагдан оролцож сэтгэл зүрхээ зориулан ажиллаж буй эмч, эрдэмтэн багш, сувилагч инженер техникч, уг үйл хэргийг дэмжигч нарыг нэгтгэн нэгэн санаа бодолтой, тэдний эрх ашгийг хамгаалах, сурч боловсрох, мэдлэг оюун ухаанаа сайжруулах, судалгаа шинжилгээ хийх өргөн бололцоог хангаж, бодлогоор дэмжин тусалж байх үүднээс сайн дураараа эвлэлдэн нэгдэж Эрхтэн Шилжүүлэн Суулгах Монголын Холбоог байгуулсан ба өнөөдөр эгнээндээ 60 гаруй гишүүнтэй болоод байна.

Бидний үйл ажиллагааны гол зорилго нь Эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээг ард олондоо илүү хүртээмжтэй, чанартай, аюулгүй хүргэж байх, үр үр дүгээр сарын 14-ны өдөр улаанбаатар хотод унтэ-ийн байранд анхны дүнг нь улам сайжруулах, энэхүү үйл ажиллагааг зохицуулж байх хууль эрх зүйн орчныг сайжруулахад мэргэжлийн талаас зөвлөлгөө, дэмжлэг үзүүлэх, гишүүдийнхээ эрх ашгийг хамгаалах, мэдлэг боловсролоо дээшлүүлэх, судалгаа шинжилгээ хийхэд бодлогоор дэмжин тусалж байхад оршино. ЭШСМХолбоо нь удирдах зөвлөл, удирдах зөвлөлийн тэргүүн, ерөнхий нарийн бичгийн дарга, хяналтын хороо, эрдэм шинжилгээ сургалт судалгаа, гадаад дотоод харилцаа хамтын ажиллагаа, мэдээлэл олон нийттэй харилцах хэсэг гэсэн дотоод зохион байгуулалттай ажилладаг ба үйл ажиллагаандаа бүх гишүүдээ жигд хамруулан оролцуулдаг.

Уг холбоонд Монгол Улсын Хөдөлмөрийн баатар 1, Монгол Улсын төрийн соёрхолт 2, Хүний гавъяат эмч 7, Шинжлэх ухааны доктор 1, Профессор 3, Анагаах ухааны доктор 17, Дэд профессор 2, Докторант 7, Зөвлөх болон тэргүүлэх, ахлах, зэргийн эмч нар, сувилагч-10 болон үйлчлэгч, урлагийн ажилтан 1 байна. Манай холбоо анх байгуулагдахад 27 гишүүнтэй байсан бол өнөөдөр эгнээндээ 64 гишүүнтэй болоод байна.

Гишүүдээс Дэлхийн Эрхтэн шилжүүлэн суулгах нийгэмлэгийн (TTS) гишүүн 10, АНУ-ын элэгний эмгэг судлалын нийгэмлэгийн гишүүн (AASLD) 3, Азийн болон бусад мэргэжлийн дагуу олон улсын нийгэмлэг холбооны гишүүд байна.

2. ХҮН АМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГА:

2.1. БОДЛОГЫН БИЧИГ БАРИМТАД ТУСГАГДСАН ЧИГЛЭЛЭЭР

- 1) Монгол улсын их хурлын 2016 оны 9 дүгээр сарын 09-ний өдрийн 45 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол улсын засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн “Иргэн бүрийг жилд нэг удаа эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх эрт илрүүлгийн үзлэгт үнэ төлбөргүй хамруулах, алслагдсан орон нутагт явуулын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үзүүлнэ” гэсэн заалтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд
- 2) Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 24 тоот тогтоолоор батлагдсан “Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого батлах тухай” бодлогын бичиг баримтын 2.4.1.12 дахь заалт буюу хүн амын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх архи, тамхины хэрэглээг хязгаарлах, архи тамхины онцгой албан татвараас Эрүүл мэндийг дэмжих санд төвлөрүүлэх, хөрөнгийг нэмэгдүүлэх асуудлыг судлан сангийн хөрөнгөөр хүн амыг өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрсдэлт хүчин зүйлийг бууруулах үйл ажиллагааг санхүүжүүлэх гэсэн заалтын хүрээнд
- 3) Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.1.3 дахь зорилт болох “Элэг бүтэн Монгол” үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган ажиллах
- 4) Монгол улсын Засгийн газрын 2017 оны “Үндэсний хөтөлбөр батлах тухай” 112 дугаар тогтоолоор батлагдсан “Элэг бүтэн Монгол” үндэсний хөтөлбөрийн 3.1.2.10, 3.2.3.6, 3.4.1.4 дэх заалтуудыг тус тус хэрэгжүүлэх зорилгоор дараах төслийг боловсруулсан.

2.2. ТӨСЛИЙН ҮЙЛЧЛЭХ ХҮРЭЭ

Уг төслийн анхны үе шатыг хэрэгжүүлэхдээ зорилтод бүлгийг сонгон авах ба үүндээ хөдөө орон нутаг хотын захын дүүрэг хорооны амьдралын нөхцөл байдал боломж тааруу иргэд хүүхэд залуучууд, орон нутгаас Улаанбаатар хотноо суралцаж буй оюутныг хамруулах болно. Төсөвт заасны дагуу 1000-1200 иргэнийг хамруулна.

ОРЛОГО БАГАТАЙ, ЭМЗЭГ БҮЛГИЙН ХҮН АМД ХҮРЧ ҮЙЛЧЛЭХ БАЙДАЛ

МУ-ын үндэсний статистикийн хороо, Нийслэлийн статистикийн газрын судалгааны дүнгээс харахд ажилгүйдлийн түвшин 2015 оны эцсийн байдлаар 6.9 байсан бол 2016 оны III-р улирлын байдлаар 9.4 болж эрчимтэй нэмэгдэж байна. Мөн 2016 оны статистик мэдээнээс харахад 15 ба түүнээс дээш насны хүн ам 2.122.313 байгаа бөгөөд үүнээс эдийн засгийн идэвхтэй иргэдийн тоо 1.262.342 эдийн засгийн идэвхгүй иргэдийн тоо 859.971, байнгын ажил эрхэлж буй иргэдийн тоо 1.147.015, ажилгүй иргэдийн тоо 115,327 байгаа нь ядуу эмзэг иргэдийн тоог улам бүр нэмэгдүүлж байгаа билээ.

Хүн амын ядуу эмзэг байдал хүн хаана оршин амьдарч байгаагаас, өөрийн болон гэр бүлийнхний орлого, эрхэлж буй ажил, өмчилж буй хөрөнгө, гэр бүлийн бүтцээс ихээхэн хамаардаг.

Ажилгүйдлийг дагаж иргэдийн ядуурал, эмзэг байдал, өвчлөл нэмэгддэг бөгөөд хөдөө орон нутгаас нийслэл хотод шилжин суурьшиж байгаа иргэд амьжиргааны түвшин доогуур, ядуу зүдүү, дэд бүтэц муу хөгжсөн, захын алслагдсан хороодод амьдарч, ямар нэгэн бүртгэлгүй, албан бус салбарт хөдөлмөр эрхэлж, эмнэлгийн тусламж үйлчилгээ авах боломж хомс байдаг бөгөөд ялангуяа сүүлийн жилүүдэд Улаанбаатарт шилжин суурьшсан өрхүүд, алслагдсан аймаг, сумдын иргэд эрүүл мэндийн мэдээ мэдээлэл туйлын хомс байдгаас өвчнөө хүндрүүлж, эцсийн шатанд хүргэн эрүүл мэнд, эдийн засгийн асуудлаа туйлын хүнд байдалд оруулдаг билээ.

Тиймээс тус төслийн хүрээнд эдгээр иргэдийн эрүүл мэндийн эмзэг байдлыг бууруулах, Монгол Улсын хэмжээнд өвчлөл, нас баралтаар тэргүүлж буй элэг, бөөр, зүрх судасны өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэгт хамрагдахын ач холбогдол, сэргийлж болох халдварт бус өвчнөөр өвдөхгүй байх, эрхтэн шилжүүлэх эмчилгээнд ортлоо өвчнөө хүндрүүлэхгүй байх талаар сургалт сурталчилгаа явуулах, эрт илрүүлэгт хамруулах ажлуудыг ядуу, эмзэг иргэдэд түлхүү хандуулна.

3. САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН ХҮЧИН ЗҮЙЛ:

Эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээний өртөг

Хүснэгт 1.

№	Жагсаалт	Нийт өртөг /төгрөг/	ЭМД /төгрөг/
ЭРХТЭН ШИЛЖҮҮЛЭН СУУЛГАХ ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ			
1. Элэг шилжүүлэн суулгах мэс засал			
1.1	Элэг шилжүүлэн суулгах мэс засал /Цогцосноос болон амьд донороос элэг шилжүүлэх үед засал /Нерабиг вирусын эсрэг тариаг хэрэглэх үед/	105 000 000	12 000 000
1.3	Элэг шилжүүлэн суулгах мэс засал /Цогцосны донороос элэг шилжүүлэн суулгах/	76 434 488	7 000 000
1.4	Элэг шилжүүлэн суулгах мэс засал /Хүүхэд/	64 212 014	7 000 000
2.Бөөр шилжүүлэн суулгах мэс засал			
2.1	Бөөр шилжүүлэн суулгах мэс засал /Өвчтөнд дархлаа дарангуйлах тариа (basiliximab) 2 ширхэгийг хэрэглэх үед/	25 580 167	4 000 000
2.2	Бөөр шилжүүлэн суулгах мэс засал /Цогцосны донороос бөөр шилжүүлэн суулгах/	26 259 197	4 000 000
3.Чөмөг, цусны үүдэл эс шилжүүлэн суулгах эмчилгээ			
3	Чөмөг, цусны үүдэл эс шилжүүлэн суулгах эмчилгээ	85 000 000	28 740 750

ТӨСЛИЙН ХИЙГДЭХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хийгдэх ажлууд	2019 он		
		06.02-06.30	0.7.01-0.7.30	12.01-12.15
Урьдчилан сэргийлэх аян хэрэгжүүлэх төслийн ажлын төлөвлөгөө				
1	Эрүүл мэндийн боловсрол сургалт хийх			
1.1	Сургалт заах багш нарын баг бүрдүүлэх			
1.2	Сургалтын материал боловсруулах			
1.3	Сургалт хийгдэх газар, үйлчлүүлэгчдийг бүртгэх			
1.4	Сургалтын талаар мэдээлэл, сурталчилгаа хийх			
1.5	Сургалт зохион байгуулах			
1.6	Үр дүнг нэгтгэж тайлан бичих			
2	Урьдчилан сэргийлэх үзлэг хийх			
2.1	Үзлэгийн баг бүрдүүлэх			
2.2	Үзлэгийн материал боловсруулж, бэлэн байдлыг хангах			
2.3	Үзлэгт хамрагдах газар, үйлчлүүлэгчдийг бүртгэх			
2.4	Үзлэг, шинжилгээ зохион байгуулах			
2.5	Үр дүнг нэгтгэж тайлан бичих			
	Урьдчилан сэргийлэх сургалт, үзлэг, зөвлөгөө з / б ажлын тайлан бичин зөвлөмжийг хүргүүлэх			

1. Эрүүл мэндийн боловсрол сургалт хийх ажлын хүрээнд

1.1 Сургалт заах багш нарын баг бүрдүүлэх

Сургалтын хичээлийг уг төслийн зорилго зорилтуудын агуулгад нийцүүлэн эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээнд хүргэж буй зонхилон тохиолддог өвчин эмгэгүүдийн талаар болон түүнээс хэрхэн урьдчилан сэргийлэх, илрүүлэх, эмчлэх талаар эрхтэн шилжүүлэн суулгах төвийн мэргэжлийн эмч багш нар заана.

Эрүүл, зөв зохистой амьдрах хэв маягийг хэвшүүлэх чиглэлийн хүрээнд нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтэн, эрхтэн шилжүүлэн суулгах төвийн мэргэжлийн эмч багш нар зөвлөгөө, сургалтыг хийнэ.

Сургалтын багийн гишүүдийн танилцуулга

№	Заах нэр	хичээлийн	Овог нэр	Мэргэжил	Зэрэг цол
1	Бөөрний эмгэг		Д.Нямсүрэн	БШС	БШСБ-ын зөвлөх АУ-ны доктор
2	Элэгний эмгэг		Д.Батчулуун	ЭШС	Клиникийн профессор
3	Цусны эмгэг		Н.Оюундэлгэр	ЯЧҮЭ ШС баг	ЯЧШС зөвлөх АУ-ны доктор
4	Элэгний эмгэг		О.Сэргэлэн	ЭШС	ЭШСБ-ын ахлагч АУ-ны доктор
5	Элэгний эмгэг		Д.Даваадорж	ЭШС	ЭШС зөвлөх АУ-ны доктор
6	Бөөрний эмгэг		Д.Баян-Өндөр	БШС	БШСБ-ын ахлагч АУ-ны доктор
7	ЭШС- лаборатори Эд нийцэл		Ж.Саранцэцэг	Эд нийцлийн тохироо	АУ-ны доктор
8	Бөөрний эмгэг		Б.Батсайхан	ЭШС эмч	Ахлах зэрэг
9	Бөөрний эмгэг		Л.Од-Эрдэнэ	ЭШС эмч	Ахлах зэрэг АУ-ны доктор
10	Бөөрний эмгэг		Н.Шүхэрцэнд	ЭШС эмч	Ахлах зэрэг
11	Элэгний эмгэг		Б.Бат Ирээдүй	ЭШС эмч	Ахлах зэрэг
12	Элэгний эмгэг		Ч.Мөнхцэцэг	ГЭТ эмч	Тэргүүлэх зэрэг
13	Элэгний эмгэг		Г.Анар	ГЭТ эмч	Тэргүүлэх зэрэг АУ-ны доктор
14	ЯЧҮЭ ШС баг		Д.Хишигжаргал	ЭШС эмч	Ахлах зэрэг АУ-ны доктор
15	Зүрх/с/эмгэг		Ц.Анхбаяр	Зүрх/с/ эмч	Тэргүүлэх зэрэг
16	Дотоод шүүрлийн эмгэг		Д.Янжмаа	Диабетийн төвийн эмч	Тэргүүлэх зэрэг
17	ЯЧҮЭ ШС баг		Э. Элбэгжаргал	ЭШС эмч	Ахлах зэрэг

Шаардлагатай тохиолдолд мэргэжил тус бүрээс эмч нарыг нэмж хамруулна.

1.2 Сургалтын материал боловсруулах

Сургалтын хөтөлбөрт багтсан бүх хичээлүүдийн ерөнхий агуулгыг багтаасан 3-4 хуудас бүхий сургалтын гарын авлага, брошурыг хичээл заах эмч мэргэжилтнүүдийн боловсруулсан эхийн дагуу бэлтгэж хэвлүүлнэ. Оролцогч бүрт сургалтанд шаардлагатай бичиг хэргийн зүйлс өгнө.

Хэвлэлийн компаниудын үнийн судалгаа (А4)

№	Байгууллагын нэр	Хаяг	1 хуудасны үнэ
1	Улаанбаатар принт	ХУД, Таван богд групп байр	270
2	Сэлэнгэ пресс	БЗД, 2 хороо, Доржийн гудамж	250

Сургалтын материал бэлтгэх, хэвлэх зардлын задаргаа

№	Зардлын зүйл	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт
1	Эх бэлтгэл	ш			
2	Хэвлэл	ш	1,000	1,000	1,000,000
3	Оролцогчдын бичиг хэрэг	ш	1,000	250	250,000
	Нийт				1,250,000

1.3 Сургалт хийгдэх газар, үйлчлүүлэгчдийг бүртгэх

Сургалтыг УНТЭ-гийн хурлын танхим болон дүүргийн ЭМТөвийн байранд өдөрт 1 удаагийн 50-100 хүний анги дүүргэлттэйгээр зохион байгуулна.

Сургалтанд хамрагдагчдыг Сүхбаатар, Баянзүрх, Сонгинохайрхан дүүрэг хорооны нийгмийн ажилтантай хамтран ажиллаж хорооны хүн ам зүйн статистик мэдээнд тулгуурлан амьжиргааны түвшин багатай иргэдийг сонгон авч нэрсийн жагсаалтийг гарган бүрдүүлэлт хийнэ.

1.4 Сургалтын талаар мэдээлэл, сурталчилгаа хийх

Сургалтын талаар мэдээлэл, сурталчилгааг тухайн дүүрэг хорооны нийгмийн ажилтантайгаар болон дүүргийн болон өрхийн эмнэлгүүдээр дамжуулан айл өрх, иргэдэд мэдээллийг шууд түгээх. Мөн олон нийтийн мэдээллийн хэрэгсэл болон цахим сүлжээг ашиглан ард иргэдэд шууд бус аргаар сургалт үзлэгийн талаар мэдээлэл түгээнэ.

1.5 Сургалт зохион байгуулах

Сургалт явуулах эмч, сургалтанд хамрагдах иргэдийн жагсаалтийг гаргасны дараа сургалтын хөтөлбөр, цагийн хуваарийг төлөвлөн гаргаж, гаргасан хөтөлбөрийн дагуу төсөл гүйцэтгэгч эмч, ажилчид сургалтыг удирдан зохион байгуулна. Сургалтыг социал медиагаар дамжуулан сурталчлах. Сургалтын талаарх мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгсэлүүд болон вэб сайтууд, социал медиагаар дамжуулан олон нийт, албан байгууллагуудад түгээнэ.

Мөн дүүргийн болон өрхийн эмч нарыг мэдээлэл сургалтанд давхар хамруулах ажлыг гүйцэтгэнэ.

1.6 Үр дүнг нэгтгэж тайлан бичих

Ясны чөмөг шилжүүлэн суулгах багийн 2 эмч, резидент 1 эмч

Зохион байгуулагчид сургалтын төлөвлөгөө хөтөлбөрийн хэрэгжилтэнд хяналт тавьж нийт сургалтанд хамрагдагчид үйлчлүүлэгчдийн ирц, идэвхи, оролцоонд тулгуурлан сургалтын үр дүнг тайлагнана.

2. Урьчдилан сэргийлэх үзлэгийн хүрээнд

2.1 Үзлэгийн баг бүрдүүлэх

Үзлэгийн багийг дараах байдлаар бүрдүүлнэ. Үүнд

- Элэг шилжүүлэн суулгах багийн 2 эмч, резидент 1 эмч,
- Бөөр шилжүүлэн суулгах багийн 2 эмч, резидент 1 эмч,
- Ясны чөмөг шилжүүлэн суулгах багийн 2 эмч, резидент 1 эмч
- Зүрх шилжүүлэн суулгах багийн 2 эмч, резидент 1 эмч
- Сувилагч 5
- Зохион байгуулагч 2 хүн

Нийт 19 хүний бүрэлдхүүнтэйгээр үзлэг шинжилгээ оношлогоог хийнэ.

2.2 Үзлэгийн материал боловсруулж, бэлэн байдлыг хангах

Үзлэгт шаардлагтай тоног төхөөрөмж, үзлэгийн багаж хэрэгслийг үзлэг хийх багийн эмч, сувилагч нар бэлтгэж үзлэгийн бэлэн байдлыг хангана.

2.3 Үзлэгт хамрагдах газар, үйлчлүүлэгчдийг бүртгэх

16
Үзлэгийг мөн УНТЭ-гийн амбулатор болон дүүрэг, хэсгийн өрхийн эмчийн байрны үзлэгийн өрөөнд хийх ба өдөрт дунджаар 20-30 хүнийг үзлэгт хамруулна. Үзлэгт хамрагдагчдыг дээрх сонгох авсан дүүрэг хорооны сургалтанд хамрагдсан иргэдийн нэрсийн жагсаалтийг үндэслэн үзлэгийн хуваарийг гарган үзлэгт хамруулна.

2.4 Үзлэг, шинжилгээ зохион байгуулах

Үзлэг шинжилгээний хуваарийг зохион байгуулагч болон эмч нар ярилцаж үзлэг хийх өдөр, үйлчлүүлэгчдийн тоог төлөвлөн гаргаж, уг төлөвлөгөө хуваарийн дагуу үзлэг шинжилгээгээ хийнэ.

ТӨСЛИЙН ТӨСӨВ

№	Хийгдэх ажлууд	Хамрагдах хүний тоо	Нэгж үнэ /төгрөг/	Нийт /төгрөг/
Урьдчилан сэргийлэх аян хэрэгжүүлэх төслийн ажлын төлөвлөгөө				
1	Сургалт зохион байгуулах ажлын хүрээнд			
1.1	Сургалтын материал, гарын авлага	1000	2 500	2 500 000
1.2	Сургалтанд оролцогчдыг бүрдүүлэх, бүртгэхтэй холбоотой бичиг хэргийн зардал	1000	1000	1000 000
1.3	Сургалт заах эмч, багш нартай холбоотой зардал /хоол, унаа /	9	250 000	2 250 000
1.4	Сургалтын цай, кофе	1000	3000	3 000 000
1.5	Харилцаа холбоо тээврийн зардалд	10	5000	50 000
	Нийт			8 800 000
2	Урьдчилан сэргийлэх үзлэг хийх ажлын хүрээнд			
2.1	Үзлэгийн материал	500	8000	4 000 000
2.2	Цуллаг эрхтний эхо	500	25 000	12 500 000
2.3	Ажилчдын хоол, унааны зардал	25	20 000	500 000
	Сургалтын багш	4	250 000	1 000 000
	Эмч	8	500 000	4 000 000
	Туслах эмч	4	300 000	1 200 000
	Сувилагч	5	300 000	1 500 000
	Зохион байгуулагч	5	200 000	1 000 000
	Нийт			25 600 000
	Төслийн нийт төсөв			34 400 000

3. ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНД ОРУУЛАХ ХУВЬ НЭМЭР:

3.1 ТӨСЛИЙН НИИГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН АЧ ХОЛБОГДОЛ

1. Хүн амд Эрүүл мэндийн болон нийгмийн эрүүл мэндийн чанартай тусламж, үйлчилгээг хүн амын хэрэгцээнд тулгуурлан тэгш, хүртээмжтэй, үр ашигтай

- хүргэхийг зорин хэрэгжүүлсэнээр эрүүл мэндийг сайжруулах, хүн амыг эрүүл мэндээс шалтгаалсан санхүүгийн эрсдэлээс хамгаалах, эдийн засгийн өсөлтийг хангах, ядуурлыг бууруулахад дэмжлэг бий болно.
2. Эрүүл мэндийн нийт зардалд хувь хүний төлөх төлбөрийн эзлэх хэмжээ 30 хувиас дээш гарсан тохиолдолд хүн амд үзүүлэх эмнэлгийн болон нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тэгш байдал алдагдана гэж ДЭМБ-аас зөвлөмж болгодог. Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэлтийн аян хийгдсэнээр хувь хүнээс шалтгаалан гарах зардал буурч иргэд үйлчлүүлэгчид санхүүгийн эрсдэлээс давхар сэргийлэгдэнэ.
 3. Хүн амын эрүүл мэндийн болон нийгмийн эрүүл мэндийн боловсрол мэдлэгийг дээшлүүлж, урьдчилсан сэргийлэх үзлэг, оношлогоонд цаг тухайд нь хамруулснаар эрхтэн тогтолцооны эмгэгийг эрт илрүүлэн эмчлэх, цаашлаад ЭШС өндөр өртөг бүхий эмчилгээнд хамрагдахаас сэргийлэн хувь хүн, ар гэр, эрүүл мэндийн байгууллагыг эдийн засаг, санхүүгийн хүндрэл, дарамтаас хамгаална.
 4. Эрхтэн шилжүүлэн суулгах хагалгааны өртөг
Сүүлийн жилүүдэд мөнгөний ханшын хэлбэлзлээс үүдэн эм, эмнэлгийн хэрэгслийн үнэ дунджаар 20% нэмэгдсэн. Иймд тус эмчилгээнүүдийн бодит өртөг огцом өссөн. Энэ хувь хүний болон ар гэрт санхүүгийн өндөр дарамт болж байдаг. Үйлчлүүлэгчдэд өөрсдийн эд эрхтэнийг яаж эрүүл байлгах талаар урьдчилан сэргийлэлт хийгдсэнээр дараах санхүүгийн дарамт буурах юм.

3.2 ХҮНИЙ НӨӨЦИЙН МЭРГЭШСЭН БАЙДАЛ

Энэхүү төслийг хэрэгжүүлэн үр дүнг тооцон гаргахад Эрхтэн Шилжүүлэн Суулгах Монголын Холбооны гишүүд буюу Бөөр, Элэг, Ясны чөмөг үүдэл эс болон Зүрх шилжүүлэн суулгах үндэсний багийн нийт гишүүд хамрагдан оролцох бөгөөд УНТЭ-ийн ерөнхий мэс засал, бөөрний мэс засал, Дотрийн эмгэг судлалын тасгийн мэргэжил дээшлүүлж байгаа болон резидент эмч, сувилагч нар хамрагдах болно. Мөн цаашлаад уг төслийн цар хүрээ, ач холбогдолыг өндөрсгөж нийт улс орны хэмжээнд нийгмийн бүх салбарыг хамруулах боломжтой билээ.

Үүндээ сонин сэтгүүл, телевиз радио болон хэвлэл мэдээлэлийн бүхий л хэрэгслэлийг ашиглан сургалт, сурталчилгаа, танин мэдэхүйн мэдээлэл

хийх болно. Уг арга хэмжээнд олны танил болсон эрдэмтэн мэргэд, шашны төлөөлөл, нэрт тамирчид, урлагийн төлөөллийг хамруулах болно.

3.3 ТӨСЛИЙН ХҮРЭХ ҮР ДҮН

Төслийн үр дүнд иргэдийг эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээнд хүргэж буй зонхилон тохиолддог өвчин эмгэгүүдийн талаар болон түүнээс хэрхэн урьдчилан сэргийлэх талаар бүрэн хэмжээний мэдлэг, мэдээллээр хангаж улмаар иргэдийг эрүүл, зөв зохистой амьдрах хэв маягийг хэвшүүлэх өөрсдийгөө болон гэр бүлээ дээрх өвчнөөс хэрхэн урьдчилан сэргийлэх тухай тодорхой цэгцтэй мэдээллээр хангана.

Нийт сургалтанд хамрагдсан иргэдийн 30 хувь нь эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээнд хүргэж буй зонхилон тохиолддог өвчин эмгэгүүдээс урьдчилан сэргийлж чадна гэж тооцоход 300 хүн уг өвчнөөс өөрсдийгөө хамгаалснаар эрүүл мэнд, ялангуяа санхүүгийн нөхцөл байдлаа бүрэн хамгаалж чадна. Эрхтэн шилжүүлэн суулгах мэс засал нь өндөр өртөгтэй эмчилгээ учраас тэр болгон бага орлоготой иргэд энэхүү эмчилгээг хийлгэж чадахгүйд хүрдэг.

1 иргэн эрхтэн шилжүүлэн суулгах мэс заслаас урьдчилан сэргийлж чадвал дунджаар эмчилгээний зардалд шаардлагатай 110-180 сая төгрөг, үүнээс ЭМД сангаас 19-25 сая төгрөг хэмнэгдснээр гэр бүлийн санхүүгийн дарамт багасах, цаашлаад нийгэм, ЭМД сан, Улсын эрүүл мэндийн төсөвт хувь нэмэр оруулах болно.

Эрүүл мэнд гэдэг нь хүн бүхний хүслэн төдийгүй, эрүүл саруул байх нь иргэн хүний нэг үндсэн эрх бөгөөд хүн төрөлхтөний түүхэн хөгжлийн турш нийгмийн чухал зорилтуудын нэгэн байсаар ирсэн түүхтэй. Эрүүл мэнд бол хүн хөдөлмөрийн өндөр бүтээл гаргах чадвартай, амьдрал буюу аж байдал нь хүрэлцээтэй, сэтгэл санааны амгалан тайван, сайн сайхан байхын чухал хэрэгцээ юм. ДЭМБ "Эрүүл мэнд гэдэг бол зөвхөн өвчин эмгэггүй байх төдийгүй, бие бялдар, оюун санаа, нийгмийн амьдралын хувьд сайн сайхан байхын цогц бүрдэл мөн" гэж томъёолсон байдаг. Өөрөөр хэлбэл эрүүл мэндийн асуудлыг зөвхөн бие бялдарын хувьд эрүүл, өвчин эмгэггүй байхаас илүү өргөн хүрээнд цогцоор нь авч үздэг. Олон улсын түвшинд хийсэн нэгэн судалгаагаар, хүний эрүүл мэндийг нөхцөлдүүлдэг хүчин зүйлсийг эерэг болон сөрөг аль ч утгаар нь 100 хувь гэж үзвэл, гадаад орчны хүчин зүйлс 20-25%, удамшлын буюу дотоод хүчин зүйлс 50-55%, эрүүлийг хамгаалахын буюу эмнэлэгийн хүчийн зүйлс 20-25% тус тус хүний эрүүл мэндэд нөлөөлдөг

гэсэн байдаг. Эндээс харахад, хүний эрүүл мэндийн асуудалд гадаад орчин, амьдралын хэв маяг буюу бидний ухамсар, мэдлэгээс хамааран өвчин тусахгүй байх, аливаа өвчнөөс урьдчилан сэргийлж болох хүчин зүйл нь 75%-ийг эзлэж байна. Харин өвчин удамших, өвчилсөн хойноо эмнэлэгээс шалтгаалах хүчин зүйл нь дөнгөж 25% байна. Тэгэхээр, хэрэв бид хичээвэл 75% өөрсдийгөө эрүүл байлгах боломж бидний гарт байна гэсэн үг юм. Иймд эрүүл мэндийн боловсрол зайлшгүй шаардлагатай.

Эрүүл мэндийн боловсрол нь ард иргэдэд орчны эрүүл мэнд, биеийн эрүүл мэнд, нийгмийн эрүүл мэнд, сэтгэл, оюун санаа, бие бялдрын эрүүл мэндийн мэдлэгийг олгож, хувь хүмүүст эрүүл мэндээ хэрхэн хамгаалах, дэмжих, хадгалах, засах арга барилд сурах зарчмыг суулгаж өгдөг.

Хүн бүр эрүүл мэндийн мэдлэгтэй байж цаашид өөрийн хариуцлагын түвшинг дээшлүүлж, амьдралынхаа төлөвлөгөөг ухамсартайгаар төлөвлөж Эх орныхоо хөгжлийн бүтээн байгуулалтанд хувь нэмрээ бодитой оруулах боломжтой юм. Ингэснээр аюулт хүнд өвчин эмгэгээс урьдчилан сэргийлж өндөр өртөгтэй эмчилгээ сувилгаанаас ангид байж эрүүл энхийн нэгэн жаргалыг эдлэх билээ. Цаашид манай улсын боловсролын хөтөлбөр, үндэсний стандартуудад зохих нэмэлт өөрчлөлтүүдийг хийж илүү боловсронгуй болгон сургалтын хөтөлбөрт түлхүү оруулах шаардлага амьдралаас урган гарч байна. Иргэн эрүүл бол, айл гэр бүр аз жаргалтай байж улмаар улс орон хөгжин дэвшинэ. Манай нийгмийн хамгийн үнэт зүйл бол ХҮН өөрөө Хүний амьдралын хамгийн үнэт зүйл бол ЭРҮҮЛ МЭНД билээ.

Төсөл боловсруулсан



П.Батчулуун

/ЭЭЭШСҮАЗА-ны

дарга/



Г.Батцэцэг / ЭЭЭШСҮАЗА-ны ахлах
мэргэжилтэн

**“ЭРҮҮЛ АМЬДРАЛЫН ТӨЛӨӨ - 2019” НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙГ ДЭМЖИХ
ТӨСЛИЙН АЖЛЫН ГЭРЭЭ**

2019 оны 08 сарын 20-ны өдөр

№ **177**

Улаанбаатар хот

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Энэхүү Ажил гүйцэтгэх гэрээ (цаашид “Гэрээ” гэх)-г нэг талаас Эрүүл мэндийг дэмжих сан(цаашид“Захиалагч”гэх), түүнийг төлөөлж Нийгмийн эрүүл мэндийн газрын дарга Т.Энхзаяа, нөгөө талаас 9086331 регистрийн дугаартай Эрүүл мэндийн яамны харъяа Эрүүл мэндийн хөгжлийн төв (цаашид“Гүйцэтгэгч”гэх), түүнийг төлөөлж дарга Б.Нарантуяа нар (цаашид хамтад “Талууд”, тус тусад нь “Тал” гэх) Монгол Улсын Иргэний хууль, холбогдох бусад хууль тогтоомж, тогтоол шийдвэр, дүрэм журмыг үндэслэн дараах нөхцөлийг харилцан тохиролцон байгуулав.
- 1.2. Энэхүү гэрээний дагуу Гүйцэтгэгч “Эрүүл амьдралын төлөө 2019” төслийн ажлыг гэрээнд заасан хугацаанд чанарын өндөр түвшинд хийж гүйцэтгэн Захиалагчид хүлээлгэн өгөх, тайлагнах, нөгөө талаас Захиалагч нь гэрээнд заасан хугацаанд төлбөрийг төлөхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулах, талуудын эдлэх эрх, хүлээх үүрэг, хариуцлага болон тэдгээртэй холбогдсон бусад харилцааг тодорхойлох, зохицуулахад оршино.

ХОЁР.ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА

- 2.1. Гэрээний үйлчлэх хугацаа: **2019/06/02-2019/12/15**
- 2.2. Хугацааг тоолохдоо гэрээнд тусгайлан зааснаас бусад тохиолдолд хуанлийн тооллыг удирдлага болгоно.

ГУРАВ.ГЭРЭЭНИЙ ҮНЭ, АЖЛЫН ҮЙЛЧИГЭЭНИЙ ТӨЛБӨР

- 3.1. Гэрээний нийт үнийн дүн нь 34 400 000 / гучин дөрвөн сая дөрвөн зуун мянган / төгрөг байна. Үүнд НӨАТ болон бусад бүх төлбөр, зардлыг оруулсан болно.
- 3.2. Талууд гэрээ байгуулж, Захиалагч нь Гүйцэтгэгчийн нэхэмжлэлийг хүлээн авснаас хойш ажлын 5 хоногийн дотор 70 хувийн төлбөрийг, Захиалагч ажлын үр дүнг бүрэн хүлээн авч, актаар баталгаажуулснаар үлдэх 30 хувийн төлбөрийг ажлын 5 хоногийн дотор Гүйцэтгэгчийн нэхэмжлэлийг үндэслэн *Төрийн Сан* банкны *100900020405* тоот дансанд тус тус шилжүүлнэ.
- 3.3. Гүйцэтгэгч нь гэрээ байгуулсны дараа гэрээний үнийг нэмэгдүүлэх эрхгүй.

ДӨРӨВ. АЖИЛ ХҮЛЭЭЛЦЭХ

- 4.1. Гүйцэтгэгч нь захиалгат ажлыг гүйцэтгэж дуусмагц Захиалагчид үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн хамт хүлээлгэн өгнө.
- 4.2. Захиалагч нь гэрээний зүйлийг шалган баримт/актаар баталгаажуулан хүлээн авна. Уг баримт/акт нь гэрээний салшгүй хэсэг болно.

ТАВ. ТАЛУУДЫН ЭРХ, ҮҮРЭГ

5.1. Захиалагчийн эрх, үүрэг:

- 5.1.1. Захиалагч нь Гүйцэтгэгчид гэрээний зүйлд заасан ажлыг гүйцэтгэх ажлын даалгавар баталж өгөх, шаардлагатай мэдээллээр хангах үүрэгтэй.
- 5.1.2. Захиалагч нь Гүйцэтгэгчийн ажлын хөлсийг гэрээнд заасны дагуу төлөх үүрэгтэй.
- 5.1.3. Захиалагч нь гүйцэтгэсэн ажлын үр дүнг гэрээнд заасан хугацаанд хүлээн авах үүрэгтэй.
- 5.1.4. Захиалагч нь ажлын гүйцэтгэлийн явц, үр дүнг шалгах эрхтэй. Ажлын даалгаварт зааснаас зөрүүтэй болон стандартын шаардлага хангаагүй тохиолдолд хүлээн авахаас татгалзах, дахин гүйцэтгэхийг шаардах, шаардлагыг хүлээн аваагүй тохиолдолд 3-дагч этгээдээр гүйцэтгүүлэх, үүнтэй холбогдон гарсан зардлыг Гүйцэтгэгчээр нөхөн төлүүлэх (төлөх ёстой төлбөрөөс суутган авах) эрхтэй.
- 5.1.5. Гүйцэтгэгч нь шаардлага хангаагүй гэрээний зүйлийг үнэ төлбөргүй буюу өөрийн зардлаар дахин/нөхөж гүйцэтгэх боломжгүй буюу гэрээнд заасан хугацаанд амжихгүйгээр хугацаа алдсан тохиолдолд Захиалагч ажлын төлбөрийг төлөхгүй байх эрхтэй.
- 5.1.6. Гүйцэтгэгч гэрээний үүргээ хоёр ба түүнээс дээш удаа биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүй эсхүл гэрээнд заасан ажил, үр дүнг хүлээлгэн өгөх боломжгүй болсон тохиолдолд төлбөр төлөхөөс татгалзан, гэрээг нэг талын санаачилгаар цуцлах эрхтэй.
- 5.1.7. Хууль тогтоомжид заасан бусад эрх, үүрэгтэй.

5.2. Гүйцэтгэгчийн эрх, үүрэг:

- 5.2.1. Гэрээгээр хүлээсэн ажил, үүргийг холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, заавар, стандартын дагуу мэргэжлийн өндөр түвшинд хийж гүйцэтгэн гэрээнд заасан хугацаанд Захиалагчид хүлээлгэн өгөх үүрэгтэй.
- 5.2.2. Гүйцэтгэсэн ажлын үр дүнг Захиалагчид хүлээлгэн өгөхөөс өмнө ажлын үр дүнд учирч болох эрсдэлийг дангаар хариуцах үүрэгтэй.
- 5.2.3. Гүйцэтгэгчийн гүйцэтгэсэн гэрээний ажил нь Захиалагчийн баталсан ажлын даалгавраас зөрсөн, өөрчлөгдсөн, чанарын шаардлага хангаагүй тохиолдолд тухайн шаардлага хангаагүй гэрээний зүйлсийг дахин үнэ төлбөргүй хийж гүйцэтгэх үүрэгтэй.
- 5.2.4. Гүйцэтгэгч нь энэхүү гэрээнд заасан үүргээ биелүүлээгүйгээс Захиалагч болон гуравдагч этгээдэд учирсан аливаа хохирлыг дангаар хариуцан арилгах үүрэгтэй.
- 5.2.5. Захиалагчийн бичгээр гаргасан зөвшөөрөлгүйгээр гэрээгээр хүлээсэн үүргээ бусад этгээдэд шилжүүлэхгүй байх үүрэгтэй.
- 5.2.6. Мөнгөн урьдчилгааны тайлан болон анхан шатны баримтууд 2019 оны 09 дүгээр сарын 30-ны өдөрт багтаан Эрүүл мэндийн яамны төсвийн ерөнхий нягтлан бодогч, биелэлт гүйцэтгэлийн тайлан ЭМДС-ийн мэргэжилтэнд хүргүүлэх үүрэгтэй.
- 5.2.7. Эрүүл мэндийг дэмжих сангийн санхүүжилтээр зохион байгуулсан, бүтээсэн, аливаа арга хэмжээ, бүтээлд Эрүүл мэндийг дэмжих сангийн нэрийг дурдах үүрэгтэй.
- 5.2.8. Гүйцэтгэгч нь гэрээний ажил үйлчилгээний төлбөрийг гэрээнд заасны дагуу төлөхийг шаардах эрхтэй.



- 5.2.9. Ажил гүйцэтгэхтэй холбогдуулан нэмэлт мэдээлэл авах эрхтэй.
5.2.10. Хууль тогтоомжид заасан бусад эрх, үүрэгтэй.

ЗУРГАА. ТАЛУУДЫН ХАРИУЦЛАГА

- 6.1. Гүйцэтгэгч ажлыг гэрээнд заасан хугацаанд хүлээлгэн өгөөгүй буюу чанарын доголдлыг тогтоосон хугацаанд арилгаагүй тохиолдолд хугацаа хэтрүүлсэн хоног тутам гүйцэтгээгүй ажлын үнийн дүнгийн 0,01 хувиар алданги тооцно.
6.2. Алданги төлсөн нь талуудыг гэрээнд заасан үүргээ гүйцэтгэх, учирсан хохирлыг нөхөн төлөхөөс чөлөөлөх үндэслэл болохгүй.
6.3. Төслийн ажлын даалгавар, үйл ажиллагааны календарчилсан төлөвлөгөө энэхүү гэрээний салшгүй хэсэг байна.

ДОЛОО. ГЭНЭТИЙН БУЮУ ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛ

- 7.1. Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлийн улмаас захиалагч буюу гүйцэтгэгч нь гэрээгээр хүлээсэн үүргээ зохих хугацаанд хийж гүйцэтгээгүй бол шаардлагатай хугацаагаар түүнийг гүйцэтгэх хугацааг сунгаж болно.
7.2. Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйл гэдэгт гал түймэр, газар хөдлөлт, салхи шуурга, аянга цахилгаан, үер г.м байгалийн гамшиг, нийтийг хамарсан үймээн, эсэргүүцлийн хөдөлгөөн, төрийн эрх бүхий байгууллагын шийдвэр, хорио цээр г.м талуудын хүсэл зоригоос үл хамаарах нөхцөл байдлыг ойлгоно.
7.3. Бараа материал, түүхий эдийн хомсдлын улмаас бий болсон үнийн өсөлт, үйлдвэрлэгч болон бараа нийлүүлэгчийн шийдвэр, хязгаарлалт нь гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлд хамаарахгүй.

НАЙМ. НУУЦ ХАДГАЛАХ БА БАТАЛГАА

- 8.1. Талууд гэрээг хэрэгжүүлэх явцад олж мэдсэн байгууллага, хувь хүний нууцад хамаарах аливаа мэдээ мэдээллийг бусдад бичгэн буюу аман хэлбэрээр задруулах, гэрээнд зааснаас өөр зорилгоор ашиглах эрхгүй.
8.2. Нууц хадгалахтай холбоотой үүргээ зөрчсөн тал нөгөө талдаа учруулсан хохирлыг бүрэн хариуцна.
8.3. Энэ заалт нь ажил гүйцэтгэгчийн бүх ажилтан, төлөөлөгчид болон туслан гүйцэтгэгч /хэрэв байгаа бол/ нарт нэгэн адил хамаарна.

ЕС. МАРГААН ШИЙДВЭРЛЭХ

- 9.1. Гэрээг биелүүлэхтэй холбогдон гарсан аливаа санал, зөрөлдөөн, маргааныг талууд зөвшилцөх аргаар эвийн журмаар шийдвэрлэнэ.
9.2. Хэрэв маргаанаа зөвшилцөх аргаар шийдвэрлэж чадахгүйд хүрвэл Монгол Улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

АРАВ. БУСАД ЗҮЙЛ

- 10.1. Гэрээ нь талуудын бүрэн эрхт төлөөлөгчид гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болж, гэрээг цуцалснаар буюу гэрээний нөхцөл бүрэн биелэгдсэнээр дуусгавар болно.
10.2. Гэрээ нь талуудын эрх ашиг, сонирхлын төлөө байгуулагдсан бөгөөд талуудын хувьд зайлшгүй дагаж мөрдөх баримт бичиг мөн.
10.3. Аль нэг талын хүсэлтээр гэрээний нөхцөлд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлага гарвал талууд харилцан тохиролцож, зөвшилцсөний үндсэн дээр


гэрээнд бичгээр нэмэлт, өөрчлөлт оруулах бөгөөд энэ нь гэрээний салшгүй хэсэг байна.

10.4. Гэрээнд тусгагдаагүй бусад асуудлыг Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу зохицуулна.

10.5. Гэрээг монгол хэл дээр 4 хувь үйлдэж, хувь тус бүр хуульзүйн адил хүчинтэй байна.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

ЗАХИЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:




НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН
ДАРГА Т.ЭНХЗАЯА

Хянасан:
Хуулийн хэлтсийн дарга
М.Ганзориг


Боловсруулсан:

Ж.Долбоон, НЭМГ-ын мэргэжилтэн


ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:



ЭРҮҮЛ МӨНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН
ДАРГА Б.НАРАНТУЯА



ЭС, ЭД, ЭРХТЭН ШИЛЖҮҮЛЭН
СУУЛГАХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ
ЗОХИЦУУЛАХ АЛБАНЫ ДАРГА
П.БАТЧУЛУУН



ЭЭЭШСҮАЗА-НЫ РЕЦИПИЕНТ
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН
Ч.БОЛОР

ЭРҮҮЛ МЭНДИЙГ ДЭМЖИХ САНГИЙН ХӨРӨНГӨӨР

2019 оны 06 сарын 12 өдөр

Дугаар 3

Улаанбаатар

**Эрүүл мэндийг дэмжих сангийн хөрөнгөөр
саяхүүжүүлэх төслийн 2019 оны эхний хэлэлцээрийн
төсөл хөтөлбөрт дэмжлэг үзүүлэх тухай**

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4, Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3, 21^д дугаар зүйлийн 21^д 2, 21^д 3, 21^д 4 дугаар зэрэг, Засгийн газрын 2017 оны 82 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Эрүүл мэндийг дэмжих сангийн хөрөнгөөр 2019 оны эхний хэлэлцээрийн төсөл хөтөлбөрт дэмжигдсэн төсөл хөтөлбөрийг хавсралтаар баталсан төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх үйлчилгээний төсөл хөтөлбөрүүдийг шилжүүлэн санхүүжүүлж ажил хэрэгжүүлэх багарт оруулахыг зөвшөөрдөг /Х Отгонзул/-д үүрэг болгосугай.
3. Энэхүү тогтоолыг хэрэгжүүлэхийн хоньбоотой өмнөд хэрэгжүүлэх төхөөрөмж байгуулалтаар хангаж ажиллахыг Нийгмийн эрүүл мэндийн газрын дарга Л Энхзаяа/-д үүрэг болгосугай.
4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналтын газрын дарга Л.Нялгээ, дотоод аудитын газрын дарга Г.Сүхбаатаралд даалгасугай.

Тэрэл

Төрөл	Хугацаа	Хүтээгч	Тусламж	Хэмжээ
21*2.4	32	Эмгэг судлалын үндэсний төв	Тусламж	50.500.000
21*2.1	33	Эмгэг судлалын үндэсний төвийн захирал Г.Уянга	FOST аймгийн газрын тусламж, БСЭМТ дүүргийн эрүүл мэндийн төвийн тусламж	11.120.000
21*2.1	34	Эмгэг судлалын үндэсний төвийн захирал Г.Уянга	FOST аймгийн газрын тусламж, дүүргийн эрүүл мэндийн төвийн тусламж, сурдагч нарыг чадавхиартай болгох тусламж	7.325.000
21*2.2	35	УБ. Хүрээ амьржих газрын захирал	Эрүүл Салур-2019	9.540.000
21*3				3.000.000
21*3	37	АНУ-УБ-ийн МАУОУСургуулийн захирал Д.Цэрэндэгва	АНУ-УБ-ийн МАУОУСургуулийн захирал Д.Цэрэндэгвагийн тусламж, бичгийн хэрэгсэл, хичээл хийх түүний ариун тусламж	800.000
21*2.1	38			15.000.000
21*3	39			40.000.000
				15.000.000





ЭРҮҮЛ МЭНДИЙН ХОГЖЛИЙН ТӨВИЙН
ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2019 оны 09 сарын 23 өдөр

Дугаар А/154

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Эрүүл мэндийн сайдын 2019 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн "Эрүүл мэндийг дэмжих сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх төслийн 2019 оны эхний хагас жилийн төсөл хөтөлбөрт дэмжлэг үзүүлэх тухай" 3 дугаар тушаал, мөн сайдын 2018 оны А/21 дүгээр тушаалын нэгдүгээр хавсралтын 4.7.6, 4.7.12 дахь заалт, ЭМЯ-ны НЭМГ, ЭМХТ хоорондын 2019 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн 177 тоот "Эрүүл амьдралын төлөө-2019" гэрээг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус төвийн Эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах үйл ажиллагааг зохицуулах албаны нийгмийн эрүүл мэндийг дэмжих төслийг хэрэгжүүлэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Ажлын хэсгийн ахлагч: П.Батчулуун /Эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах үйл ажиллагааг зохицуулах албаны дарга/

Нарийн бичгийн дарга: П.Тунгалаг /Мэдээний сан хариуцсан мэргэжилтэн /

Н.Золзаяа /Реципиентийн асуудал хариуцсан мэргэжилтэн/

Төслийн гишүүд: Ж.Саранцэцэг /Эрхтэн шилжүүлэн суулгах Монголын холбооны нарийн бичгийн дарга /

Б.Бат-Ирээдүй /УНТЭ, Эрхтэн шилжүүлэн суулгах төвийн дарга /

Л.Од-Эрдэнэ /УНТЭ, Бөөр судлалын эмч/

Ч.Мөнхцэцэг /УНТЭ, Гастроэнтерологийн төвийн дарга /

Б.Хишигжаргал /УНТЭ, Цусны эмгэг судлалын эмч /

Э.Элбэгжаргал /УНТЭ, Цусны эмгэг судлалын эмч /

Г.Батцэцэг /Эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах үйл ажиллагааны зохицуулалт хариуцсан ахлах мэргэжилтэн /

Б.Алтантулга /Донорын асуудал хариуцсан мэргэжилтэн /

2. Төслийг хэрэгжүүлсэн ажлын тайланг 2019 оны 12 дугаар сарын 01-ний дотор удирдлагын зөвлөлд танилцуулах, ЭМЯ-ны нийгмийн эрүүл мэндийн газарт хүргүүлэхийг Ажлын хэсэг /П.Батчулуун/-д үүрэг болгосугай.

3. Төслийн зардлыг төсвийн холбогдох зардлаас тооцож олгохыг Ахлах нягтлан бодогч /Б.Очир/-д зөвшөөрсүгэй.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, санхүү, дотоод хяналтын албаны дарга /Т.Содгэрэл/-д даалгасугай.

ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН

ГҮЙЦЭТГЭГЧ



Б.НАРАНТУЯА

420505

